

Дорнод аймгийн Хэрлэн сумын ЕБ-ын 12 дугаар сургуулийн бага ангийн багш
Г.Оюунтуяа (Боловсрол судлалын магистр, Тэргүүлэх багш)
И-мэйл хаяг: oyuntuyagombo150@gmail.com утас: 89207907

- Илтгэлийн сэдэв: “Эцэг эхэд эерэг хандлага бий болгоход дэмжлэг үзүүлэх нь”
- Илтгэлийн хураангуй:

Хүүхэд төрсөн орчин, хүрээлж буй хүмүүсээс байнга суралцаж хөгждөг. Хүүхдийн сэтгэл зүйчид, “Асуудал эцэг эхчүүдэд байдаг болохоос биш хүүхдэд байдаггүй” гэж үздэг. Хүүхдүүд бол эцэг эхчүүдийн хуулбар юм. Тиймээс хүүхдүүддээ эцэг эхчүүд бүх талаараа үлгэр дуурайл үзүүлэх ёстой юм.


Эцэг эхчүүдийн боловсрол ямар байх нь тийм ч чухал биш гагцхүү эерэг зөв хандлагатай байж, сургууль, багшид хандах хандлагыг өөрчлөх зайлшгүй хэрэгцээ бий болсон байна.

- Илтгэлийн үндэслэл:


Боловсролын чиг хандлага дэлхийн даяаршил, хөгжлийг дагаад эрчимтэй хөгжиж байгаа энэ цаг үед үр хүүхдээ чанартай боловсрол эзэмшүүлж, нийгэмд хэрэгтэй зөв хүн болоход чиглүүлэгч, дэмжигч, туслагчийн үүрэг гүйцэтгэдэг хүмүүс бол багш нар байдаг билээ. Гэвч хүүхэд өдрийн ихэнх цагийг гэртээ өнгөрүүлдэг төдийгүй, энэхүү цагийг эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамтдаа үр бүтээлтэй өнгөрүүлж, хамтдаа суралцах нь зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болоод байна. Сургууль, багшид хүүхдээ даатгаад орхидог эцэг эхийн тоо төдийлэн буухгүй байгаа нь нууц биш бөгөөд энэ нь зөвхөн эцэг эхчүүдийн ХАНДЛАГА-аас ихээхэн шалтгаалж байгааг судалж, шийдэх гарц, арга замыг хайж ажиллаж байгаагаа туршлага болгон хүргэхээр шийдлээ.

- Судалгаа:


Хэрлэн сумын ЕБ-ын 12 дугаар сургуулийн бага ангийн нийт 201 эцэг эхээс анкетын аргаар, 1-3-р ангийн нийт 50 гаруй эцэг эхээс сурвалжлагын аргаар судалгаа хийсэн.



Судалгаанд оролцогчдын насны байдлаар авч үзвэл, 20-25 насны эцэг эх дийлэнх эь буюу 30%-ийг эзэлж байна. Үүнээс үзэхэд, эцэг эхчүүдийн нас залуужиж байгаа нь харагдаж байна. Мөн 51-ээс дээш насны эцэг эхчүүдийн хувьд өөрийн хүүхдийг өргөж авсан, аль эсвэл асран хамгаалагч нь болж байгаа юм.



Судалгаанд оролцогчдын боловсролын түвшинг судалж үзэхэд, 73 эцэг эх буюу 36% нь тусгай дунд боловсрол эзэмшсэн байна. Дээд боловсролтой 31 эцэг эх байгаа хэдий ч эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг нь 20 эцэг эх байна.



Оролцогчдын 109 нь буюу 54% нь огт ажил эрхэлдэггүй байгаа нь анхаарал татсан хэдий ч хааяа улирлын чанартай ажил, тогтмол биш хөлсний ажил эрхэлдэг болохоо тодруулсан юм.

- Сурвалжлагын судалгааны дүгнэлт:

Манай сургуулийн хувьд залуу эцэг эхчүүд олширсон, боловсролын түвшингийн хувьд харилцан адилгүй байгаа боловч ажил хөдөлмөр эрхэлдэггүй эцэг эхчүүд дийлэнх нь байгаа нь ажиглагдаж судлагдсан тул хүүхдэдээ цаг зав гаргаж ажиллах боломжтой гэсэн дүгнэлтийг судлаачийн зүгээс гаргаж байна.

- Та хүүхдэдээ зав гаргаж ажиллаж чаддаг уу? гэсэн асуултанд тийм-89, үгүй-112 гэж хариулсан нь ихэнх эцэг эхчүүд зав гаргаж чаддаггүй гэсэн дүгнэлтэнд хүрч байна.
- Танд хүүхэдтэйгээ ажиллахад ямар асуудал тулгардаг вэ? гэсэн асуултанд:
 1. Хичээлийг нь ойлгодоггүй
 2. Сурах бичгийн агуулга хүнд
 3. Ажилтай болохоор оройтож ирдэг
 4. Зааж өгөөд байхад ойлгодоггүй
 5. Зөрүүд, үгэнд ордоггүй
 6. Хүүхдэдээ заах арга олдоггүй, гар хүрэх гээд байдаг

7. Өөрсдийн мэдлэг дутдаг зэрэг олон шалтгаануудыг гаргаж ирсэн. Тэгвэл боловсролын систем шинэчлэгдэн хувьсан өөрчлөгдөж буйтай агаар нэгэн эцэг эхчүүд энэ өөрчлөлтийг эерэгээр хүлээн авч, хүүхэдтэйгээ хамтарч ажиллах

шаардлага бий болсныг мэдрэх хэрэгтэй. Эцэг эхчүүд хүүхдээ анх сургуульд орох үеэс эхлэн ажиглаж мэдрэх нь чухал. Хүүхдэд доорх шинж тэмдгүүдийн хэд хэд нь илэрч байгаа бол нүд, сонсголыг нь эхлээд шалгуулах ёстой.

- Авиа үсгээ ялгаж чаддаггүй
- Үсгүүдээ мэдэх боловч холбож хэлж чадахгүй
- Аль хэдийн бичиж сурсан байх ёстой үндсэн үгсийг нэг зөв, нэг буруу уншаад бичээд байх
- Цээж бичиг бичихээс айдаг, дургүйцдэг
- Давтлага аваад байгаа боловч унших, бичих нь сайжрахгүй, хуучин алдаагаа дахин давтах
- Хичээлийг нь давтуулаад байхад л амжилтгүй байдаг
- Хүүхэд сэтгэл санааны хувьд хичээл хийх дургүй байх
- Хүүхэд уйлж эцэг эхийн тэвчээр алдагдах
- Гэрийн даалгавар хийх гэж бөөн тэмцэл болох
- Хичээл хийх, сургуульд явах дургүй
- Анхаарал төвлөрөлт муу байх
- Хичээл дээр үймүүлж, багш болон бусдад саад болох
- Тайван бус, хумсаа мэрэх
- Өмнөхөөсөө илүү нойр нь муудах, уйламтгай болох
- Ямар нэг шалтгаангүй толгой гэдэс нь өвддөг болох

Дээрх шинж тэмдгээс хэд хэд нь илэрч байгаа бол олон улсын өвчний 10 дугаар ангилалд багтсан F 80-Хэл ярианы хөгжлийн өвөрмөц эмгэг (сульдах) гэж үздэг. (Barbetta, Patrica, Norona, Kathleen, Bocard, David, 2005; Rachel, Daniel, 2012; Yuan, 2012) Эцэг эхчүүд хүүхдэдээ гарч буй доголдол, эмгэгийг анги удирдсан багш, мэргэжлийн эмч, сэтгэл зүйчтэй хамтран судалж, оношлох шаардлагатай. Хүүхэдтэйгээ ажиллаад байхад ахиц гарахгүй байгаа тохиолдол олон байдаг. Сургалтын төвд илүү цагаар хичээллүүлэх нь хүүхдэд эргээд дарамт учруулдаг.

- Дүгнэлт:

Бага ангийн хүүхэдтэй эцэг эхчүүдэд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, хүүхэдтэйгээ хэрхэн ажиллаж болох арга зүй, туршлагыг хүргэх ажлуудыг анги удирдсан багш нар санаачлан зохион байгуулснаар эцэг эхийн хандлагыг өөрчилж чадна.

Дэвшүүлж буй санал

Дээрх дүгнэлтээс дараах саналыг дэвшүүлж байна. Бага ангийн багш нар танин мэдэхүйн чадамж болох сэтгэн бодох, асуудал шийдвэрлэхээс илүү хэл-нийгмийн чадамж (харилцах, хамтран суралцах), амьдрах ухааны чадамж (бие даах, байгаль орчинтой зөв харьцах)-уудыг хөгжүүлэх нь чухал байна. Мөн ахмад үеэсээ суралцах, тэднээр бахархах, уламжлалт ёс заншлаа дээдлэх, гэр бүлтэйгээ өнгөрүүлэх цагийг үр дүнтэй бүтээлч болгох шаардлагатай.

Багш нар

- Хичээлийн жилийн эхэнд хүүхэд бүрээ оношилж судлан, эцэг эхтэй ганцаарчилж уулзах график гарган мөрдөж байх
- Эцэг эхчүүдийн боловсрол, ажил эрхлэлтийн бодит судалгааг үнэн зөв гаргах
- Хичээлдээ эцэг эхчүүдийг урьж оролцуулах, сурган хүмүүжүүлэх хичээл, хандлагыг өөрчлөх лекц унших, сургалт зохион байгуулах
- Эцэг эхийн хурлыг өвөрмөц хэлбэрээр зохион байгуулах (дугуй ширээний уулзалт ярилцлага, кофе юу, цай юу, хэлэлцүүлэг, чин сэтгэлийн уулзалт, ганцаарчилсан ярилцлага гэх мэт)
- Хүүхдийн хэрэгцээ сонирхлыг нь татан, өөрийнх нь дэвшүүлсэн асуудлыг л авч үзэх
- Асуудлыг аль болох танхимаас гадуур нөхцөлд олж харахад багш туслах, аялал экскурс хийх, үйлдвэр, үйлчилгээний газар, тариалангийн газар, малчны хотонд очих гэх мэт
- Сургалтаа хүүхэд бүрийн оролцоог хангаж байхуйцаар зохион байгуулах
- Эцэг эх, орон нутгийн байгууллагын ажилтнуудад энэ ажлаа сайн ойлгуулах, дэмжлэгийг олж авах, оролцоог нь идэвхжүүлэх ажлыг сургуулийн удирдлагатай хамтран хэрэгжүүлэхэд онцгой анхаарах
- Багш нар багаараа болон анги бүлгүүд хоршиж, зохион байгуулалтад орж ажиллахыг чухалчлах

- Хүүхдүүд тухайн асуудлыг шийдвэрлэхэд би, бид хэрхэн яаж оролцох вэ гэдэг өнцгөөс асуудалд хандаж сургахыг багш чухалчлах

Орон нутаг, эцэг эхийн хамтын ажиллагаа

- Хүүхдийнхээ тухайн жилийн судлах хөтөлбөрийг эцэг эх судлан мэдэж, хичээлийн хуваарь, хичээлд хэрэглэгдэх зүйлсийг тогтмол бэлдэж өгөх
- Хүүхдэдээ амин дэмтэй хоол хүнс, сурах орчинг бүрдүүлж өгөх, хөдөлгөөн дасгалыг хамтдаа хийх
- Хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, судлаач багш нартай жилд нэг удаа уулзалт ярилцлага зохион байгуулж, шийдэл гарц олоход дэмжлэг үзүүлэх
- Завтай болохоороо биш зав гаргаж хүүхэдтэйгээ ажиллах
- Аль болох цаг зав гаргаж чадах, мэргэжлийн хувьд найдвартай зөвөлгөө өгч чадахуйц, түүх соёл уламжлалаа сайтар мэддэг хүмүүсийг сонгоход анхаарлаа хандуулах
- Багш бусад багш нартай хамтран сургуулийн эргэн тойронд судалгаагаа сайн явуулах, хөрөнгө зардал, цаг бага гаргах боломжийг эрэлхийлэх
- Сургуулийн удирдлагатай уулзан төлөвлөлтөө танилцуулан сум орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллага хүмүүстэй холбох, хамтрах боломжийг бүрдүүлэх, нөөцийг ашиглах, өдөр тутмын хамтын ажиллагааны систем бий болгох
- Сурагчид танхимын бус сургалтын нөхцөлд тэдний аюулгүй байдлыг анхаарахад эцэг эх, орон нутгийн иргэдийн сайн дурын оролцоог ханган ажиллах

Эцэг эхчүүдийн эерэг хандлагыг бий болгоход багшийн зүгээс ямар дэмжлэг үзүүлж болохыг зөвлөмж болгон хүргэж байна.

- Хүүхдэдээ авиаг тусгаж, таньж ялгахад нь туслаарай.
- Хичээл, сургуулиас айх айдсыг намжаах
- Анхаарлыг нь төвлөрүүлэх, булчин суллах дасгал хийлгэх
- Өөрөө өөртөө туслах аргыг заах
- Алдаагаа хянах болон өөрийгөө урамшуулах аргуудыг эзэмшүүлэх

- Гаргасан алдаа, бүтэлгүйтлээ хэрхэн даван туулах сэтгэлзүйн боловсрол олгох
- Хумсаа мэрэх болон орондоо шээх зэрэг шинж тэмдгүүд дээр ажиллаарай.
- Хүүхдийг байгаагаар нь хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.
- Аль болох мэдрэхүйн олон эрхтнийг идэвхжүүлэх орчныг бүрдүүлээрэй.
- Багш, сэтгэл зүйч, мэргэжлийн эмч нартай хамтран эмгэгийн шалтгааныг зөв тодруулан, хүүхдийн сул талыг нөхөх давуу талыг нь нээж, урамшуулан хөгжүүлэхэд анхаарах

Ашигласан ном, эх сурвалж:

- 1) Батдэлгэр, Ж. (2011). Бага насны хүүхдийн сэтгэл судлал. Улаанбаатар.
- 2) Батсүх, С. (2014). Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй. Улаанбаатар.
- 3) Батхуяг, С. (2003). Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс. Улаанбаатар.
- 4) Батхуяг, С. (2015). Амжилттай суралцах арга зам. Улаанбаатар: Содпресс.
- 5) Батхуяг, С., Төртогтох, Б., Цогзолмаа, Н. (2015). *Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник*. Улаанбаатар: Хүслийн өнгө
- 6) Дюлмаяр Бернд (2008): Бага ангийн танхимын бус сургалт, Шнайдер хэвлэлийн газар
- 7) Файге Бернд (2006): Бага ангийн сурган хүмүүжүүлэх ухаан Дэвтэр 11, хуудас 3-7
- 8) Залцман Кристиан (2007): Иргэний боловсролын хичээлийн заах аргазүй хуудас 433-438
- 9) https://de.wikipedia.org/wiki/Au%C3%9Ferschulischer_Lernort